АЖИЛЛАГСДЫН АМЬДРАЛЫН ДААТГАЛ

HR DEPARTMENT

ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Группын ажиллагсдыг жам ёсны үхэл, бүх төрлийн өвчин, гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хэсэгчлэн алдах, мөн бүх төрлийн өвчин, гэнэтийн ослын улмаас нас барах эрсдэлээс хамгаалах

АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН ДАВУУ ТАЛ

- Хүний амь насыг өвчин болон гэнэтийн ослоос даатгадаг.
- Гэрээг урт хугацаагаар байгуулдаг.
- Жам ёсны үхэл, бүх төрлийн өвчин, гэнэтийн ослын улмаас нас барвал нөхөн төлбөрөө 100% авна.
- Гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 80-100% алдвал 100%-ийн нөхөн олговор олгоно. 80%-аас бага бол алдсан хувиар олгоно.
- Ердийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдвал нөхөн олговрыг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр олгоно.
- Хамгаалалт дэлхий дахинд үйлчилдэг.
- 24 цагийн турш гэр, ажил, гадаа хаана ч байнгын хамгаалалттай.

АЖИЛЛАГСДЫГ АМЬ НАС, ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫН ДААТГАЛД ХАМРУУЛАХ

Үндсэн хамгаалалт

Даатгагдагч гэрээний хугацаанд нас барах

Нэмэлт хамгаалалт

Хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдах

Хөдөлмөрийн чадвар бүрэн алдах

ДААТГАЛД ХАМРАГДАХ ШАЛГУУР

- **Нас:** 20-59 нас
- **Группт ажилласан жил:** 5 болон түүнээс дээш жил
- **Нэмэлт нөхцөл:** Ажилтан өмнө нь даатгалд хамрагдсан бөгөөд даатгал үргэлжилж байх хугацаанд 60-65 настай болсон бол даатгал 66 нас хүртэл нь үргэлжлэх боломжтой

АЖИЛТАНД ЗОРИУЛСАН ДААТГАЛ



БЕНЕФИШЕР

- Даатгалын нөхөн төлбөрийг олгохоор гэрээнд нэрлэж заасан даатгагдагчийн зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээдийг бенефишер гэнэ.
- Даатгагдагч нь даатгалын тохиолдол бий болсон үед өөрөө нөхөн төлбөрөө авах боломжгүй тохиолдолд нөхөн төлбөрийг бенефишерт олгоно.
- Даатгалын тохиолдол бий болохоос өмнө даатгагдагч нь бенефишерээ өөрчилж болно.

ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛД ХАМААРАХГҮЙ ЭРСДЛҮҮД

Даатгагдагч нь гэрээ байгуулахаас өмнө тахир дутуугийн 1, 2-р зэргийн групптэй байсан, эсхүл дараах нөхцөл байдал үүссэн байсан бөгөөд тэдгээр нь даатгалын тохиолдол болох шалтгаан болсон тохиолдолд нөхөн төлбөр олгохгүй.

- Хорт хавдраар өвчилсөн, элэгний В, С вирус тээгчийн улмаас эмнэлэг диспансерын байнгын хяналтанд байдаг
- ДОХ-оор өвчилсөн, ХДХВ-ийн халдвар авсан нь тогтоогдсон
- Эмчилгээний болон бусад зориулалтаар мансууруулах болон хортой бодис хэрэглэдэг, архинд донтох өвчтөн
- Мэдрэлийн болон сэтгэл санааны гүн хямралд ордгийн улмаас эмнэлэг диспансерийн хяналтанд байгаа өвчтөн /унах, татах өвчтэй хүмүүс г.м/

ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛД ХАМААРАХГҮЙ ЭРСДЛҮҮД

Дараах үйлдлийн улмаас бий болсон тохиолдлыг даатгалын тохиолдолд тооцохгүй бөгөөд нөхөн төлбөр олгохгүй. Үүнд:

- Даатгагдагч амиа хорлосон
- Даатгуулагч даатгагдагчийн амь насыг санаатай хохироосон
- Даатгагдагч санаатайгаар эд эрхтэнээ гэмтээснээс
- Даатгагдагч мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх, гүн хордлогод оруулах эм бэлдмэл хэрэглэсний улмаас
- Даатгагдагч согтууруулах ундаа хэрэглэснээс гүн хордлогод орсны улмаас
- Даатгагдагч тээврийн хэрэгслийг согтуугаар жолоодсон, жолоодох эрхгүйгээр жолоодсон, жолоодох эрхгүй этгээдэд жолоо шилжүүлснээс
- Даатгагдагч гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхийг завдсан, гэмт хэргийн зохион байгуулагчаар оролцсоноос
- Даатгагдагч ДОХ-р өвчилсний улмаас

ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛД ХАМААРАХГҮЙ ЭРСДЛҮҮД

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр
- Цөмийн дэлбэрэлтийн үйлчлэл, цацраг идэвхит бодисын тархалт, хордлогын улмаас
- Дайн байлдааны үйл ажиллагаанаас
- Нийтийг хамарсан үймээн самууны улмаас
- Зэвсэгт хүчин болон цэрэгжүүлсэн бусад байгууллагад ажиллах, цэргийн хээрийн сургуулилт, цэргийн техник туршилтын болон түүнтэй ижил төстэй бусад төрлийн үйл ажиллагаанд оролцох
- Даатгагдагчийн сэтгэцийн гүн хямрал, гэнэтийн ослын бус шалтгаанаар үүссэн уналт, таталт, саажилт
- Жирэмслэлт, төрөлт түүний хүндрэл
- Нийтийн зориулалтын бус агаарын нислэгт оролцох, бэртэж гэмтэх магадлал өндөртэй спортын төрлөөр хичээллэх, уралдаан тэмцээнд оролцох, хичээллэх

ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОЛТ

Аль ч тохиолдолд нөхөн төлбөр авах (өвчин болон гэнэтийн ослын улмаас)



- Даатгагдагч нас барсан бол үндсэн даатгалын үнэлгээг 100%
- Даатгуулагч гэрээний хугацаанд хөдөлмөрийн чадвараа 80% болон түүнээс дээш хэмжээгээр алдвал нөхөн төлбөрийг 100% олгоно.
- 1-80% алдвал даатгалын үнэлгээг хөдөлмөрийн чадвар алдсан хувиар тооцож олгох.
- Хөдөлмөрийн чадвараа алдаад нөхөн төлбөр авсны дараа нас барвал даатгалын үнэлгээгээр нөхөн төлбөр олгогдоно.



ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ БИЙ БОЛСОН ҮЕД ЯАХ ВЭ?

- Даатгуулагч/даатгагдагч/бенешифер даатгалын тохиолдол бий болсон тухай даатгагчид нэн даруй буюу 72 цагийн дотор мэдэгдэх бөгөөд үүнээс хойш ажлын 30 хоногийн дотор багтаан даатгагчид нөхөн төлбөрийн материалыг ирүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгаантай бол энэ хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.
- Даатгагч бүрэн гүйцэд материал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор нөхөн төлбөр олгох эсэхийг шийдвэрлэнэ.
- Даатгагч нөхөн төлбөр олгох тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын 5 хоногийн дотор нөхөн төлбөрийг олгоно.
- Нөхөн төлбөрийг гэрээний дагуу бенешиферийн банкны дансанд шилжүүлгээр, эсхүл даатгагчийн кассаас бэлэн мөнгөөр олгоно.

НӨХӨН ТӨЛБӨРИЙГ ОЛГОХОД ШААРДАХ БИЧИГ БАРИМТУУД

Даатгагдагч нас барсан тохиолдолд:

- Нөхөн төлбөр авахыг хүссэн өргөдөл
- Иргэний бүртгэлийн байгууллагаас олгосон нас барсны гэрчилгээ, МУ-ын харъяат даатгагдагч гадаад улсын нутаг дэвсгэр дээр нас барсан бол хилийн чанад дахь МУ-ын дипломат төлөөлөгчийн болон консулын газарт Иргэний бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгүүлсэн баримт бичгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
- Нас барсныг тогтоосон эмнэлгийн байгууллага, эсхүл өрхийн эмнэлгийн тодорхойлолтын хуулбар
- Осолд орсон бол осол болсныг нотлох мэргэжлийн байгууллагын тодорхойлолт
- Эмнэлэгт нас барсан бол өвчний түүхийн хуулбар
- Гэртээ нас барсан бол амбулаторын картын хуулбар
- Шүүх эмнэлгийн дүгнэлт
- Нөхөн төлбөрийг авах эрх бүхий этгээд буюу бенефишерийн иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар, бенефишерийг заагаагүй бол даатгагдагчийн өв залгамжлагчийн өв залгамжлах эрхийн гэрчилгээ
- Даатгалын баталгааны хуулбар
- Байгууллагын хүсэлт

НӨХӨН ТӨЛБӨРИЙГ ОЛГОХОД ШААРДАХ БИЧИГ БАРИМТУУД

Хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд:

- Нөхөн төлбөр авахыг хүссэн өргөдөл
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Эмнэлгээс гарах үеийн эмчийн дүгнэлт /эпикриз/ дэлгэрэнгүй бичигдсэн амбулаторын карт
- Эмнэлгийн хуудас /лист/
- Осолд орсон бол осол болсныг нотлох мэргэжлийн байгууллагын тодорхойлолт
- Эмнэлэгт мөнгө төлсөн бол төлбөрийн баримт, квитанци
- Даатгалын баталгааны хуудас
- Байгууллагын хүсэлт

Даатгуулагчийн өв залгамжлах эрх бүхий этгээдэд нөхөн төлбөр олгох тохиолдлууд

- Бенефишер даатгагдагчийн амь насыг санаатай бүрэлгэсэн
- Бенефишер болон даатгагдагч нэгэн зэрэг нас барах
- Бенефишер даатгагдагчаас өмнө нас барсан
- Даатгагдагч бенефишерийг нэрлээгүй.

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

- Ердийн өвчлөлийн жагсаалт дотор дараах зүйлс байдаггүй байсныг нэмж оруулсан. Үүнд:
  - Сонсголын тэнцвэрийн эрхтэнтэй холбоотой үйл ажиллагааны өөрчлөлт
  - Хамрын салстын архаг үрэвсэл
  - Уушигны идээт өвчнүүд
  - Гялтангийн идээт архаг үрэвсэл
  - Уушигны хагалгаанч дараах байдал
  - Зүрхний мэс заслын дараах үе
- Мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдол хамрагддаггүй байсныг нэмж оруулж өгсөн.
  - Мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас ХЧАлдсан эсэхийг зөвхөн “Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төв”-өөс тогтоосон ХЧА-ын хувийг баримталж явна. Дүүрэг болгонд байдаг гэсэн.

АНХААРАХ ЗҮЙЛ

- Даатгуулагч гэрээ болон баталгаанд бичигдсэн овог, нэр, хаяг /удаан хугацаагаар гадаад улсад зорчих, амьдрах тохиолдолд тухайн улсад байх хаяг мөн хамаарна/, иргэний үнэмлэх болон бусад бичиг баримт өөрчлөгдсөн бол 30 хоногийн дотор даатгагчид мэдэгдэх үүрэгтэй.
- Даатгагдагч даатгалын баталгааг хаяж үрэгдүүлсэн бол уг баталгааг хүчингүй болсныг зохих журмын дагуу зарлуулж даатгагчид албан бичгээр хүсэлт гарган баталгааны хуулбарыг авах ёстой.
- Даатгуулагч оношоо тавиулахдаа гэрээн дээр заасан онош тухайн хавсралтад байгаа эсэхийг эмчээрээ хянуулж үзээд оношоо тавиулж байхыг анхааараарай.

ХУРААМЖ

- Хураамж нь нас, ажлын онцлог, даатгалын үнэлгээ, үргэлжлэх хугацаа зэргээс хамаарна.

- Хураамжийг компаниас төлнө.

БУСАД

- Даатгалын нөхөн төлбөр нь ХХОАТ-ын хуулийн 16.1.4-т зааснаар татвараас чөлөөлөгдөнө.

Ажилтан та М-Си-Эс группэд удаан хугацаанд тогтвортой ажиллавал группын зүгээс ажилтнууддаа үзүүлж буй хөнгөлөлт хангамж болгон уг амьдралын даатгалыг хийж байгаа болно.

ХОЛБОО БАРИХ

- **Хаяг:**

  Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 15А/5, Амбассадор оффис 5 давхар
- **Утас:** 976-70110784
  Факс: 976-70110745
- **И-мэйл:** info@nationallifedaatgal.com
  Вэб: www.nationallifedaatgal.com

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!